

Хяналт шалгалт хийсэн тухай

Хяналт шалгалтын зорилго

Сангийн сайдын баталсан 2017 оны 05 сарын 22-ны өдрийн нэгдсэн удирдамж, Санхүүгийн хяналт аудитын албаны даргын баталсан 2017 оны 06 сарын 05-ны 1/15 дугаар удирдамжийн дагуу аймгийн Автотээврийн төвийн 2016 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Автотээврийн тухай хуулиуд болон бусад холбогдох хууль эрх зүйн актуудын хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд оршино.

Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, албан тушаал, хугацаа

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч О.Гантуяа

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ж.Оюун

2017 оны 06 дугаар сарын 05-аас ажлын 10 хоног

Шалгалтанд хамрагдсан байгууллага, объектын нэр

Булган аймгийн Автотээврийн төвийн 2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаа хамрагдав.

Шалгалтанд хамрагдсан асуудал

Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн гаргасан заавар, журам, дүрмийн хэрэгжилтийн байдал

Үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөлт, түүний гүйцэтгэлийн байдал

Харилцах дансны болон кассын орлого, зарлагын гүйлгээг үндсэн баримтууд, бараа материал, үнэт цаасны тайлан, хөрөнгийн бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн журналууд, дансны бичилтүүдтэй тулган шалгах

Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан тэнцэл гаргалт, хөрөнгийн тооллого, тооцоо бодолтын байдал

Байгууллага хоорондын тооцоо өглөг авлага, түүний баталгаажуулалт, бүртгэл тайланд тусгасан байдал

Ажиллагсдын цалин хөлс, шагнал урамшууллыг хууль тогтоомжийн дагуу тогтоож, бодож олгосон байдал

Гадаад, дотоод албан томилолтын зардлын тооцоо төлсөн байдал

Автомашин ашиглалт, шатахуун, сэлбэгийн тооцоо бодолтын байдал

Зээл тусламж, эргэж төлөгдөх нөхцлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт үр дүн

Тэмдэглэлт өдөр, ой, баяр наадамд зарцуулсан хөрөнгийн байдал

Нягтлан бодогчийн хууль тогтоомжинд заасан үүргийн биелэлт

Өмнөх шалгалтаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, актын барагдуулалт

Дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байдал

Шалгалтанд хамрагдсан объектын талаарх

ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Засгийн газрын 2015 оны 55 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх Тээвэр авто замын газрын чиг үүргийг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-тай нэгтгэн зохион байгуулсан. Тус Автотээврийн төв нь дарга, менежер, ахлах нягтлан бодогч, техникийн хяналтын үзлэгийн инженер, тээврийн бүртгэлийн мэргэжилтэн, тээвэр зохицуулагч 3, тасалбар түгээгч 2, техникийн хяналтын үзлэгийн техникч, нярав, бичиг хэрэг, үйлчлэгч, харуул 3, автотээврийн улсын байцаагч /гэрээгээр/ тус бүр 1 нийт 17 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

2016 оны 01 сарын 01-нээс 2016 оны 05 сарын 04-ний өдрийг хүртэл 1-р гарын үсгийг дарга Х.Гантулга, 2016 оны 05 сарын 05-наас 2016 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл 1-р гарын үсгийг дарга Н.Амгалан, 2016 оны 01 сарын 01-нээс 2016 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал 2-р гарын үсгийг нягтлан бодогч Д.Нансал нар тус тус зурсан ба төрийн банкинд үйл ажиллагааны зарлагын 120000347974 тоот, хот хоорондын зорчигч тээврийн орлогын 120000388413 тоот, аймаг хоорондын зорчигч тээврийн орлогын 120000388421 тоот, техникийн хяналт үзлэгийн орлогын 120000347963 тоот, тээврийн хэрэгслийн бүртгэлийн орлогын 120000391042 нийт 4 данстайгаар орлого, зарлагын гүйлгээ хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох “Unicus” программаар бүртгэж хөтөлсөн байна.

Өмнөх шалгалтын талаар

Булган аймгийн Аудитын газраас Автотээврийн төвийн 2015 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийж аудитын явцад 2404.7 мянган төгрөгийн зөрчлийг барагдуулж, 1129.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 57531.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага бичиж хүргүүлсэн байна. 1129.1 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулсан.

Автотээврийн үндэсний төвийн хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс Булган аймгийн автотээврийн төвийн 2016 оны 04, 12 дугаар саруудад ажиллагсдын цаг ашиглалтын байдал, бусад хяналт шалгалт хийх шалгалтын удирдамж ирсэн ч шалгалтын баталгаажсан баримт материал санхүүгийн баримтанд байхгүй.

Тус төвийн 2016 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд бусад байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Шалгалтын явцад хийгдсэн ажил, шийдвэрлэсэн асуудал

Автотээврийн төвийн 2016 оны касс харилцахын баримт, няравын материалын тайлан, үйл ажиллагааны тайлан, нийгмийн даатгалын болон татварын, санхүүгийн тайлан, хот хооронд болон орон нутгийн орлогын баримт, оношлогоо болон ачаа тээврийн баримт материалд тулгуурлан Дарга Н.Амгалан, нягтлан бодогч Д.Нансал, тасалбар түгээгч С.Нарантуяа, Ө.Нандинцэцэг, Д.Энхмаа, Д.Ганбаатар, Х.Жавхлантөгс, автотээврийн хяналтын улсын байцаагч Б.Авирмэд нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийлээ.

Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө гүйцэтгэл: /мян.төг/

№	Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Техникийн хяналт үзлэгийн орлого /НӨАТ-тай/	105000.0	109149.6
2	Хот хоорондын зорчигч тээврийн 4,8 хувь	34000.0	25299.3

3	Орон нутаг	4000.0	5025.9
4	Дотоод ачаа тээвэр	40000.0	9176.2
5	Бүртгэлийн орлого	5300.0	3891.5
6	Бусад орлого	1500.0	1627.2
7	Хүүгийн орлого /харилцах дансны/		174.3
	Нийт дүн	189800.0	154344.0

Дээрх хүснэгтээс харахад техникийн хяналт үзлэгийн орлогыг 4.2%, орон нутгийн орлогыг 25.6%, бусад орлогыг 6.6%-иар тус бүр давуулан биелүүлж, хот хоорондын зорчигч тээврийн орлогыг 25.6%, дотоод ачаа тээврийн орлогыг 77%, бүртгэлийн орлогыг 26.5%-иар тус тус төлөвлөгөө тасарсан байна.

1. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн орлого:

Тээврийн хэрэгслийг техникийн хяналт үзлэгт хамруулах ажлыг жилийн төлөвлөгөөний дагуу сар улирлаар хуваарь гарган орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангахдаа он сард календарчилсан төлөвлөгөөг гарган ажилласан.

2016 онд 9000 тээврийн хэрэгсэл хяналтын үзлэгт хамруулах төлөвлөгөөтэйгээс 9190 тээврийн хэрэгсэл хамруулснаас 42 суудлын автомашин, 15 ачааны автомашиныг давтан үзлэгт хамруулсан байна. Үүнээс суудлын автомашин 4046, ачааны автомашин 3846, автобус 279, тусгай зориулалтын автомашин 85, механизм 89, чиргүүл 106, мотоцикл 682 нийт 9190 тээврийн хэрэгсэл техникийн үзлэгт хамруулж төлөвлөгөөгөө 2.1%-иар давуулан биелүүлсэн. Техникийн хяналт үзлэгийн орлогын 120000347963 тоот дансанд нийт 130171.4 мянган төгрөгийн орлого орсноос үзлэгийн орлого 119461.1/НӨАТ-тэй/ мянган төгрөг, Булган аймгийн Сэлэнгэ сумын ЗДТГ-ын андуурагдаж орсон цалин 10241.4 мянган төгрөг, үзлэгийн урьдчилж төлсөн орлого 469.0 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

2. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн орлого:

Тус онд тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг журам зааврын дагуу 1119 тээврийн хэрэгсэлд шилжилт хөдөлгөөн хийгдсэнээс улсын дугаар сольсон 557, эзэмшигч өөрчилсөн 935, орон нутгийн шилжилт 498, өнгө сольсон 7, шинээр 164 мотоциклд дугаар өгч, 52 тээврийн хэрэгсэлд нөхөн гэрчилгээ олгож, баталгаажуулан мэдээ тайланг цахим архивт шилжүүлэн өдөрт нь дамжуулан ажиллажээ. Бүртгэлийн орлогын 120000391042 тоот дансанд нийт 22508.4 мянган төгрөгийн орлого орсноос Жи Эл Ти ХХК-ний 5020477303 тоотдансанд дугаарын үнэ 12527.0 мянган төгрөг, Орон нутгийн орлогын 041400995 тоот дансанд тэмдэгтийн хураамж 3712.5 мянган төгрөг, Спейшл ХХК-д Зарын үнэ 165.0 мянган төгрөг, үзлэгийн орлого 120000347963 тоот дансанд 983.9 мянган төгрөг, Автотээврийн үндэсний төвийн 340004041556 тоот дансанд гэрчилгээний үнэ 701.0 мянган төгрөг, Техникийн хяналтын үзлэгийн 120000347963 тоот дансанд үүлэгийн орлого 4324.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Бичиг хэргийн зардалд 108.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3. Хот хоорондын зорчигч тээврийн орлого:

Хот хооронд болон орон нутагт зорчих тээврийн үйлчилгээ эрхлэн явуулдаг дараах аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулан ажиллажээ. Үүнд: Улаанбаатар хотоос Булган аймагт Хараацайн жигүүр ХХК, Эрдэм транс ХХК, Улаанбаатараас Гурванбулаг, Дашинчилэн, Баяннуур чиглэлд “Шуудан тээх” ХХК зэрэг аж ахуй нэгжүүд зорчигч тээврийн үйлчилгээгээ өргөтгөн дунд оврын автобусаар долоо хоногт 3 удаа тогтмол

цагаар үйлчилсэн. Хот хооронд Эрдэм транс, Хараацайн жигүүр ХХКомпаниуд нь 357 рейс явж, 9818 том хүн, 874 хүүхэд тээвэрлэн нийт 172458.8 мянган төгрөгийн тээвэрлэлтийн орлогоос 172380.5 мянган төгрөгийг дансанд тушааж 78.3 мянган төгрөгийг дутуу тушаасан болон гэнэтийн ослын даатгалын хураамж аваагүй, 13 зорчигчоор буцаасан тасалбарын үйлчилгээний төлбөрт 32.2 мянган төгрөгийг төлүүлэхээс 3 зорчигчоор 7.5 мянган төгрөгийг төлүүлж 10 зорчигчоор 24.7 мянган төгрөгийн төлбөрийг төлүүлээгүй байна. Шуудан тээх ХХК-ний орлогын 4% болох 968.9 мянган төгрөг, ачаа тээврийн орлогын 9117.9 мянган төгрөг тус бүрийг төвлөрүүлсэн.

4. Орон нутгийн зорчигч тээврийн орлого:

Аймаг хооронд Орхон аймгаас Эрдэнэ транспорт ХХК, эрдэнэт арслан ХХК, Булган аймгаас “Булган жолоо” ХХК, Залманхангай ХХК зэрэг аж ахуйн нэгжүүд, Тэшиг, Хутаг-өндөр, Баян-агт сумдаас Булган-Орхон аймгийн чиглэлд Залманхангай ХХК, Сайхан сумаас Булган аймгийн чиглэлд Сайхан транс ХХК, Сэлэнгэ сумаас Орхон аймгийн чиглэлд “Өгөөмөр зам” ХХК, Хялганат тосгоноос Орхон аймгийн чиглэлд “Хялганат зам” ХХК, Хишиг-өндөр, Орхон, Могод, Гурванбулаг чиглэлд “Шуудан үйлчилгээний алба” тус тус зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээг явуулжээ. Орон нутгийн орлогын 120000388421 тоот дансанд нийт 13762.8 мянган төгрөгийн орлого орж 12610.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, техник ашиглалтын дэвтрийн үнэ 137.0 мянган төгрөг, 3 ш медалийн үнэ 36.0 мянган төгрөг, залманхангайн тээвэр зохицуулагчид 75.0 мянган төгрөгийн тусламж, андуурч тушаасан 405.0 мянган төгрөгийг бүртгэлийн орлогын дансанд, 405.1 мянган төгрөгийг ЖЭТ ХХК-д тус тус шилжүүлсэн байна.

Булган аймгийн Автотээврийн төвийн автотээврийн улсын байцаагч нь 2016 онд 90 ш шийтгэврийн хуудсаар 3126.0 мянган төгрөг, 5 ш торгуулийн хуудсаар 25.0 мянган төгрөг нийт 3151.0 мянган төгрөгийг торгуулийн орлогыг аймгийн хүү торгуулийн орлогод оруулсан байна.

Орлогын дансдуудын үлдэгдэл

Дансны нэр	Дансны дугаар	Эхний үлдэгдэл	орлого	зарлага	Эцсийн үлдэгдэл
Хот хоорондын орлогын данс	120000388413	113928	192949416	193021925	41419
Орон нутгийн орлого данс	120000388421	9000	13762805	13681036	90769
ТХҮзлэгийн орлогын данс	120000347963	10000	130170414	130171414	9000
ТХБүртгэлийн орлогын данс	120000391042	30294	22508400	22522594	16100

Төсөвт зардлын талаар /мян.төг/

2016 онд төсөвт зардлыг 239128.2 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 233238.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. Ажилчдын цалинд 177082.1 мянган төгрөг, ндш-д 19001.2 мянган төгрөг, тогтмол зардалд 22227.1 мянган төгрөг, хангамжийн бараа материалд 3306.3 мянган төгрөг, үл хөдлөх болон бусад татварт 3146.0 мянган төгрөг, томилолт 3112.5 мянган төгрөг, урсгал засвар, сэлбэг хэрэгсэл 160.0 мянган төгрөг, хог хаягдал, хөдөлмөр хамгааллын зардалд 622.9 мянган төгрөг, ахмадын зардалд 650.0 мянган төгрөг, гадаад зочин баяр ёслолын зардалд 888.0 мянган төгрөг, ЭМ-ийн үзлэг, мэдээлэл сурталчилгааны зардалд 143.5 мянган төгрөг,

төлбөр хураамж бусад татваруудад 101.7 мянган төгрөг, банкны хураамж 171.8 мянган төгрөгийг тус бүр зарцуулсан мөн ажлаас чөлөөлөгдсөн 3 ажилтны 1 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж 2175.0 мянган төгрөг, төрийн дээд шагналын дагалдах мөнгөн шагнал 150.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтээр авч зарцуулсан байна.

Цалин 6492.7, НДШ 3315.7, гэрэл цахилгаан 547.1, цэвэр бохир ус 532.6, хог хаягдал 108.0, хөдөлмөр хамгаалал 174.0, төлбөр хураамж 187.3, ном хэвлэл 90.0, ЭМ-ийн үзлэг 190.0, баяр ёслолын зардлыг 302.0 мянган төгрөг нийт 11939.4 мянган төгрөгийг хэмнэж, татварын зардлыг 179.5, түлш халаалтын зардлыг 2174.0, бичиг хэрэг 176.2, шуудан холбоо 417.1, томилолт 172.5, сэлбэг хэрэгсэл 110.0, урсгал засвар 50.0, мэдээлэл сурталчилгаа 23.5, банкны хураамж 91.8 мянган төгрөг нийт 3394.6 мянган төгрөгийг төлөвлөснөөс хэтрүүлэн зарцуулсан байна.

Нягтлан бодогч Д.Нансалыг 2015 оны санхүүгийн тайлангаа цаг хугацаанд зөрчил дутагдалгүй АТҮТ-д тушаасныг харгалзан 1.5 сарын цалин буюу 1050.0 мянган төгрөгөөр шагнаж урамшуулсан. Мөн Төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнагдах үед шагналын дагалдах мөнгөн шагнал 150.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллаас олгосон. 2016 оны 12 сарын 21-ны өдрийн Автотээврийн үндэсний төвийн захирлын Б/772 дугаар тушаалаар тээвэр зохицуулагч Д.Энхмааг, Б/773 дугаар тушаалаар тээвэр зохицуулагч Ю.Бадамдоржийг, Б/774 дүгээр тушаалаар менежер Х.Гантулга нарыг ажлаас чөлөөлж амралтын дуусгавар тооцоо хийж, нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж нийт 2175.0 мянган төгрөгийг олгосон байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын тайлангаар:

2016 оны үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 638732.7 мянган төгрөг дээр Автотээврийн үндэсний төвөөс 13000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийн утаа зайлуулах төхөөрөмж, 365.7 мянган төгрөгийн оффисийн ширээ, 211.7 мянган төгрөгийн сандал нийт 13577.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авч, жилийн эцэст 652310.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

Бараа материалын 2016 оны эхний үлдэгдэл 2043.6 мянган төгрөг дээр бичиг хэрэг 605.0 мянган төгрөг, аж ахуйн материал 1464.2 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 1527.5 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 116.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны 51 дүгээр тогтоолоор баталсан Тээвэр авто замын газрын 970.8 мянган төгрөгийн аж ахуйн материал, автотээврийн үндэсний төвөөс 1014.5 мянган төгрөгийн хангамжийн материалыг тус тус шилжүүлэн авч 4780.1 мянган төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 3481.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна

Өглөг, авлагын талаар:

2016 онд 270.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн, 6.5 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварын өглөгтэй тайлан гарсан байна.

Шилэн дансны талаар: Автотээврийн төв нь шилэн дансны хуулийн дагуу 2016 онд мэдээллийг бүрэн тавьсан ч батлагдсан төсөв гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг 35, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт 29, бусад мэдээлэл 41, нийт 105 мэдээллийг хоцроож мэдээлсэн байна.

Шалгуулагчийн ололттой болон дэвшилттэй тал

1. Санхүүгийн тайлан балансыг цаг хугацаанд гаргаж тушаасан

2. Эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг зохих маягтын дагуу бүртгэж архивласан.
3. 4 төрлийн орлогын дансны хуулгыг сар бүр тасалбар түгээгч, тээвэр зохицуулагч, тээвэрлэгч компани нэг бүрээр журналыг сар бүр гаргаж боловсруулсан.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал

1. Автотээврийн байгууллагын 90 жилийн ойн 3 ш медалийн үнэ 36.0 мянган төгрөгийг Автотээврийн үндэсний төвийн 340004009911 тоот дансанд, Залманхангай ХХК-ний 5090368153 тоот дансанд тодорхойгүй 75.0 мянган төгрөгийг тус тус орон нутгийн орлогоос зарцуулсан нь "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын Захирлын 2015 оны 06 сарын 24-ний өдрийн А/115 тоот тушаалын хавсралт "Аймгийн автотээврийн төв"-ийн нийтлэг дүрмийн 3.1.2-д /Ажил үйлчилгээний орлогыг үйлдвэрийн газарт бүрэн төвлөрүүлэх, үйлдвэрийн газраас олгосон санхүүжилтийг батлагдсан хуваарь, зориулалтын дагуу зарцуулах/ заасан заалтыг зөрчсөн.

2. Сайхан сумаас Булган аймгийн чиглэлд зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлдэг Сайхан транс ХХК-ий гэрээнд зорчигчийн үнэ тарифийг тусгаагүй.

3. Шуудан үйлчилгээний алба нь Хишиг-өндөр, Орхон, Могод, Гурванбулаг сумын чиглэлд, Хялганат зам ХХК нь Хялганат тосгоноос Орхон аймгийн чиглэлд тус бүр зорчигч тээврийн үйлчилгээ үзүүлж орон нутгийн орлогын зохих хэсгийг бүрдүүлж ажилласан ч, Аймгийн Автотээврийн төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулаагүй нь "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын Захирлын 2015 оны 06 сарын 24-ний өдрийн А/115 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Аймгийн автотээврийн төвийн нийтлэг дүрмийн 4.3.3-д /Иргэн хуулийн этгээдтэй аймгийнхаа нутаг дэвсгэрийн хүрээнд үйлчлэх аливаа гэрээг Үйлдвэрийн газарт танилцуулж зөвшөөрөл авсны үндсэн дээр гэрээ байгуулах/ заасан заалтыг зөрчсөн.

4. 2016 оны 04 сарын 29-ний 97 дугаар төлбөрийн хүсэлтээр 25.0 мянган төгрөгийн модемын сунгалтыг дарга, нягтлан бодогчийн гарын үсэг, тамга тэмдэггүйгээр гүйлгээ хийсэн.

5. Шаардах хуудсыг оны эхнээс дугаарлаагүй, батлагдсан маягтын дагуу бүрэн бичилт хийдэггүй.

6. 2016 оны 10 сарын 28-ны 97 дугаар төлбөрийн хүсэлтээр Булган Мээж ХХК-ний Төрийн банкны 120000030382 тоот дансанд 1309.0 мянган төгрөгийн халаалтын зардлыг хот хоорондын орлогын 120000388413 тоот данснаас шилжүүлсэн. 2016 оны 12 сарын 28-нд буцааж хот хоорондын тээврийн орлогын дансанд 900.0 мянган төгрөгийг шилжүүлж, 409.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлж санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна.

7. 2016 оны 11 сарын 10-ны 41310186 дугаар төлбөрийн хүсэлтээр хот хоорондын орлогын 120000388413 тоот данснаас Н.Амгалангийн Төрийн банкны 360000132518 тоот дансанд 300.0 мянган төгрөгийг шилжүүлсэн нь автотээврийн байцаагчийн Хөвсгөл дэх сургалт, оюутан тээвэр удирдамжийн зардалд зарцуулсан гэж байгаа ч ямар ч баримт байхгүй байна.

8. Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн Булган аймгийн зөвлөлөөс ирүүлсэн 2016 оны 03 сарын 10-ны өдрийн 21 дүгээр албан бичгээр "Өсвөр үеийн" улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдын замын зардалд хөнгөлөлт үзүүлэхийг хүссэн байна. Уг хүсэлтийн дагуу хөнгөлөлт үзүүлэх эсэх талаар хариу явуулаагүй, баг тамирчдад хөнгөлөлтөөр олгохыг зөвшөөрсөн нотлох баримтгүй, зөвхөн амаар өгсөн шийдвэрийн дагуу тасалбар түгээгч С.Нарантуяа нь 2016 оны 03 сарын 13-нд 1998-2000 оны 10 том хүнд хүүхдийн тарифаар тооцож 86000 төгрөгийн замын зардал олгосон байна.

9. Хот хоорондын зорчих тасалбарт зарим зорчигчийн регистрийн дугаарыг тавиагүй, тавьсан ч гю05..., ...03...,2008..., га20080211..гэж хагас дутуу бичдэг, зарим тасалбарт зорчигчийн нэр, регистрийн дугаар харагдахгүй мэдээлэл дутуу

хэвлэгдсэн, мөн зорчигчийн мэдээллийг дээр дээрээс нь давхарлаж хэвлэн унших боломжгүй болгож засварласан байна.

10. Хот хоорондын зорчих тасалбарын үнийг 13-аас дээш насны 43 зорчигчид том хүний тарифаар тооцож худалдсан, 5 зорчигчид том хүний тарифаар худалдсан ч хүүхдийн тарифаар тооцож, ... мянган төгрөгийг дутуу тушаасан, 73 зорчигчоос гэнэтийн ослын даатгалын хураамж төгрөгийг аваагүй, 2016 оны 07 сарын 20-нд 35 зорчигчид 571600 төгрөгийн тасалбарыг худалдсан ч 34 зорчигчид худалдсанаар тооцон 554800 төгрөгийг тушааж, 1 зорчигчийн тасалбарын үнэ 16800 төгрөг дутуу тушаасан.

11. Мөнхбаяр, Гиваасамбуу, Ариун-Эрдэнэ, Бямбадорж, Учрал-Эрдэнэ, Ариунгэрэл, Бадамханд, Ууганцэцэг, Батжаргал, Норжмаа, Билгүүн,,, нарын 13 зорчигч тасалбараа буцааж, тасалбарын үнийг буцаан олгосон гэж байгаа ч олгосныг нотлох баримтгүй, тасалбар буцаасан 10 зорчигчоос /Батжаргал, Норжмаа, Билгүүн нараас бусад/ тасалбарын үнийн дүнгийн 15 хувьтай тэнцэх $24750 / 16500 * 15\% * 10$ хүн/ төгрөгийн үйлчилгээний төлбөр төлүүлээгүй.

12. Тасалбар түгээгч Ө.Нандинцэцэг нь 01 сарын 18-нд 32 зорчигчид олгосон тасалбарын үнэ 455600 төгрөгөөс 100000 төгрөгийг 1 сарын 21-нд, тасалбар түгээгч Д.Энхмаа нь 04 сарын 01-нд 19 зорчигчид олгосон тасалбарын үнэ 286400 төгрөгөөс 100000 төгрөгийг 04 сарын 15-нд, тасалбар түгээгч Б.Байгальмаа нь 10 сарын 30-нд 30 зорчигчид олгосон тасалбарын үнэ 471200 төгрөгөөс 200000 төгрөгийг 11 сарын 29-нд, 11 сарын 12-нд 20 зорчигчид олгосон тасалбарын үнэ 327800 төгрөгийг 11 сарын 21-нд, 12 сарын 05-нд 18 зорчигчид олгосон тасалбарын үнэ 302400 төгрөгийг 12 сарын 16-нд тус тус тушаасан байгаа нь тухай бүр орлогыг харилцах дансанд хийдэггүй байна.

Авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө өгсөн байдал

Нярав тус төвд хэрэглэгдэж байгаа үнэт цаасны нэр төрлийн тайланг мөнгөн дүнгүйгээр зөвхөн тоо хэмжээгээр гаргадаг, тайланг батлагдсан маягтын дагуу гаргаагүй, тээвэр зохицуулагч нар нягтлан бодогчтой тооцоо нийлэхдээ үнэт цаас нэг бүрийн үнэ, серийн дугаар, тухайн сард авсан, зарлагадсан тоо хэмжээгээр тайланг гаргаж өгдөггүй зөвхөн тухайн сарын үлдэгдэл тоог гараар ноорог цаасан дээр бичиж өгдөг, нягтлан бодогчийн тооцоо нийлсэн актаарх тоо хэмжээ, тээвэр зохицуулагч нарын зарцуулсан тоо хэмжээ хоорондоо зөрүүтэй, тээвэр зохицуулагч өөрийн авсан үнэт цаасыг бусад тээвэр зохицуулагчдад ямар ч баримтгүйгээр олгодог, няраваас тээвэр зохицуулагчид олгосон 12 сарын 08-ны өдрийн зарлагын баримтаар хот хоорондын зорчих тасалбар 200 ш байхад няравын архивт хадгалагдаж буй санхүүгийн баримтад тухайн тээвэр зохицуулагчид 250 ш тасалбар өгсөн зэрэг зөрчлүүд илэрсэн нь үнэт цаасны тооцоолол хийх боломжгүй байсан учир хугацаатай албан шаардлага өгөв.

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж таслан зогсоох зорилгоор 3 актаар 1162.0 мянган төгрөгийн төлбөрийг аймгийн төсөв болон АТҮТ-ийн дансанд төвлөрүүлэхээр акт тогтоолоо. Шалгалтын хугацаанд 6 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Дүгнэлт

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.6, 14.4.3 дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй, шаардах хуудсыг оны эхнээс дугаарлаагүй, бүрэн бичилт хийгдээгүй, хот хоорондын зорчих тасалбарт бичилтийг бүрэн бичдэггүй, том хүний тасалбарыг хүүхдээр бичдэг, аман шийдвэрээр гүйлгээ хийдэг, ажил

үйлчилгээний орлогыг зориулалт бусаар зарцуулдаг, Автотээврийн үндэсний төвийн дүрэм, хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, автотээврийн үндэсний төвийн еоффисоор ирсэн албан бичгийг бүрэн архивладаггүй зэрэг нь байгууллага дотооддоо бүртгэлээр тавих дотоодын хяналтыг сулруулсан байна гэж дүгнэлээ.

Цаашид анхаарах асуудал

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АТҮТ-ийн нийтлэг дүрэм, дотоод журам, хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс өгсөн зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах

АТҮТ-өөс гарч байгаа тушаал, эрх зүйн акт болон ААНБ-тай хийсэн гэрээг тухай бүр авч бичиг хэрэгт архивлах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, акт, албан шаардлагын биелэлтийг албан тоотоор хүргүүлж ажиллах

БИЧСЭН: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
БАЙЦААГЧ
О.ГАНТУЯА
Ж.ОЮУН